

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ,  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН  
ЛАБОРАТОРИ УТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Ц.ГАНТӨМӨР ТАНАА

2020.02.27 № 06/628  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал Ц.Гантөмөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үндсэн хөрөнгө, анхан шатны баримт, худалдан авах ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын үндсэн зорилгоо “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, Монгол Улсын мал сүргийг эрүүлжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сахин хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс малын эм, биобэлдмэлийн чанарын сорилт, баталгаажуулалтыг үндэсний болон олон улсын фармакопейн шаардлагын дагуу гүйцэтгэж, чанартай баталгаатай эм, биобэлдмэлийг хэрэглэгчдэд нийлүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мал эмнэлгийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

2019 оныг “Мал эмнэлгийн ерөнхий газар”-аас “Малчинд ойрхон мал эмнэлэг” зорилтыг дэвшүүлсэнтэй холбогдуулан “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” УТҮГ-аас “Лабораторийн чадавхийг дээшлүүлэх жил” болгон дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах 2019 оны зардал, санхүүгийн төлөвлөгөөг гаргаж оны төсөв, төлөвлөгөөнд тусгуулах, батлуулах,
- Мал эмнэлгийг чанарын баталгаатай, эм биобэлдмэлээр хангах, төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс эм, биобэлдмэлд сорилт гүйцэтгэн, баталгаажуулалт хийх,
- Амь сорил, био аюулгүйн туршилтын лабораторийн барилга болон конторын барилгын зураг төсвийг гарган шинээр барих
- Сорилтын лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх, био аюулгүй байдлыг сахин хамгаалах, багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах, компьютер, техник хэрэгслийг шинэчлэх,
- Монгол Улсад үйлдвэрлэгдэж буй болон импортоор орж ирж байгаа малын эм, био бэлдмэл, түүхий эдийн нэгдсэн цахим системд холбох,
- Лабораторийн шинжилгээнд ашиглаж буй эм урвалж, стандарт бодисыг шаардлага хэмжээгээр хангах,
- Эмч мэргэжилтнүүд, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гадаад, дотоодын сургалтанд хамруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас

хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous-4.0” программ хангамж ашигладаг байна.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 116,390.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1.163,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 9,684.4 мянган төгрөгөөр материаллаг түвшин тогтоосон нь тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс тооцсонтой холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 149,780.0 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,125.3	-	(1,125.3)
Авлага	12,801.4	96,689.5	83,888.1
Урьдчилгаа	-	66.9	66.9
Бараа материал	73,523.3	146,368.6	72,845.3
Үндсэн хөрөнгө	940,737.6	934,842.6	(5,895.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,028,187.5</b>	<b>1,177,967.5</b>	<b>149,780.0</b>
Өр төлбөр	7,112.9	199.7	(6,913.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,021,074.7	1,177,767.8	156,693.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,028,187.5</b>	<b>1,177,967.5</b>	<b>149,780.0</b>



Авлагын оны эхний 12,801.4 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй, татаас санхүүжилтийн авлага 84,000.8 мянган төгрөг шинээр бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхнээс 72,845.3 төгрөгөөр өссөн нь зарим төрлийн эм бэлдмэлийн нөөц, ашиглах хугацаа дуусаж, өндөр өртөг бүхий эм, бэлдмэлийг тендер зарлан бэлтгэснээс шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр дүнгээр тайлагнасан үндсэн хөрөнгө (барилга байгууламж)-д 99,588.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант хугацаанд тендер зарлан 74,994.5 мянган төгрөгийн барилга угсралтын их засварын ажил хийсэн байна.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь 5,800.0 мянган төгрөгийн "Динамик" онлайн программ худалдан авснаас шалтгаалж биет бус хөрөнгө өссөн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь тайлант онд 109,416.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Нийт зардлын 714,962.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 109,416.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 189,823.7 мянган төгрөгийг дээд шатны байгууллагаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 938,408.0 мянган төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн 96,730.0 мянган төгрөгөөс 12,729.3 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулж, автомашин худалдан авахаар санхүүжүүлсэн 84,000.8 мянган төгрөгийг Сангийн яамнаас татан төвлөрүүлснээс оны эхний авлага нэмэгдсэн байна..

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 1,053,809.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,053,517.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 291.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвийн 714,962.1 мянган төгрөгийн санхүүжилтийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр, дээд шатны төсвийн захирагчаас олгосон 189,823.7 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төвлөрсөн төсвийн санхүүжилтээр тайлагнасан байна. Энэ нь санхүүгийн Нягтлан бодох бүртгэлийн 2 дугаар бүлгийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд залруулсан.



2. Тайлант хугацаанд худалдан авсан 15 төрлийн нийт 13,185.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөнд 1,959.8 мянган төгрөгийн элэгдэл тооцож байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, үнэн зөв байдал, оршин байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

3. Тайлант хугацаанд 38 төрлийн нийт 973,430.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн элэгдлийг 46,839.8 мянган төгрөгөөр дутуу байгуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, үнэн зөв байдал, оршин байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

4. Сангийн яаманд татан төвлөрүүлсэн 84,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

5. Нийгмийн даатгалын тайланг цахим НД-8 маягттай тулгахад ажилтан Ц.Тунгалагтуяагийн нийт 15,932.2 мянган төгрөгийн цалин С.Сүрэнхүүгээр тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 3 дугаар бүлгийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тайлагнал ба толилуулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар илэрсэн 291.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн дэлгэрэнгүйг хувь хүний орлогын албан татварын тайлантай тулгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансанд 9 удаагийн мэдээг хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн гүйлгээг мэдээлээгүй байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Нийт 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” дүгнэлт

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. *Анхан шатны баримттай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авалт хийхдээ харилцагч байгууллагын зарлагын баримттай боловч төлбөрийн баримт /и баримт/-ыг хавсаргаагүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын 3.5 дугаар заалтуудыг мөрдөж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 2. *Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал*

##### 2.1. Илрүүлэлт:

ХХОАТ-ын хөнгөлөлтийг тайлант хугацааны эцэст дахин тооцоолж 9 ажилтны 61.2 мянган төгрөгийг дутуу, 20 ажилтны 230.7 мянган төгрөгийг илүү нийт 291.9 мянган төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварыг зөрүүтэй тайлагнасан байна.

##### 2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.

### 2.3. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.6-д заасан заалтуудыг мөрдөж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 3. Шилэн данстай холбоотой асуудал

### 3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 9 удаагийн мэдээг хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг баримтлаагүй байна.

### 3.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахгүй байх

### 3.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хуудсанд мэдээллийг тогтмол оруулж хэвших, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах.

### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,449,933.04	243,124,928.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,125,247.39	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	113,925.19	-
31110	Төгрөг	113,925.19	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,011,322.20	-
3121	Төгрөг	1,011,322.20	-
31213	Арилжааны банк дахь харилцах	1,011,322.20	-
33	АВЛАГА	12,801,365.92	96,689,470.26
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	12,788,400.00	12,688,702.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	84,000,768.26
335	Бусад авлага	12,965.92	-
3351	Байгууллагаас авах авлага	12,965.92	-
34	УРЬДЧИЛГАА	-	66,854.39
34600	Урьдчилж гарсан зардал	-	66,854.39
35	БАРАА МАТЕРИАЛ	73,523,319.73	146,368,604.24
351	Түүхий эд материал	4,974,347.33	12,057,250.08
35110	Тусгай зориулалттай материал	4,974,347.33	9,345,860.08
35130	Эм боох материал	-	2,711,390.00
354	Хангамжийн материал	63,979,972.40	111,900,454.16
35410	Бичиг хэргийн материал	2,334,615.00	4,783,613.00
35420	Аж ахуйн материал	50,557,572.33	73,578,216.93
35440	Түлш, шатах тослох материал	35,000.00	753,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,052,785.07	32,785,624.23
35600	Мал амьтад	4,569,000.00	22,410,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	940,737,599.53	934,842,618.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	940,737,599.53	934,842,618.90
392	Биет хөрөнгө	888,091,912.10	877,632,800.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	502,109,150.00	575,351,872.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,103.50)	(38,060,324.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,038,000.00	40,038,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,371,333.45)	(35,371,333.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,028,837,559.05	1,037,119,159.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(652,285,574.03)	(708,908,441.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,237,732.40	47,486,732.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,402,518.37)	(40,142,863.15)
39217	Ном	-	120,000.00
393	Биет бус хөрөнгө	52,645,687.43	57,209,817.97
39301	Програм хангамж	1,210,000.00	7,010,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(924,000.04)	(1,484,444.46)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,697,400.00	52,697,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(337,712.53)	(1,013,137.57)

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,028,187,532.57	1,177,967,547.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,112,886.47	199,716.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,112,886.47	199,716.00
413	Өглөг	6,649,486.47	199,716.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	575,089.00	199,716.00
4136	Бусад өглөг	6,074,397.47	-
41361	Байгууллагад төлөх өглөг	6,074,397.47	-
414	Урьдчилж орсон орлого	463,400.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	463,400.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,021,074,646.10	1,177,767,831.79
51	Засгийн газрын хувь оролцоо	1,021,074,646.10	1,177,767,831.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,233,840,996.88	1,233,840,996.88
51101	Өмч: - төрийн	1,233,840,996.88	1,233,840,996.88
512	Хуримтлагдсан үр дүн	(663,908,166.84)	(507,214,981.15)
51210	Өмнөх үеийн үр дүн	(663,908,166.84)	(663,908,166.84)
51220	Тайлант үеийн үр дүн	-	156,693,185.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	451,141,816.06	451,141,816.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,028,187,532.57	1,177,967,547.79

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	398,860,288.68	1,125,132,053.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	398,860,288.68	123,616,323.99
120	Нийтлэг татварын бус орлого	398,860,288.68	123,616,323.99
120002	Хүүгийн орлого	35,722.39	192,509.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	398,824,566.29	123,423,814.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	398,824,566.29	123,423,814.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,001,515,730.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	714,962,050.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	714,962,050.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	286,553,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	189,823,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	96,730,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	116,393,510.24	968,438,868.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,393,510.24	968,438,868.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,393,510.24	882,807,908.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	125,237,573.13
210101	Үндсэн цалин	-	125,237,573.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,220,975.67
210201	Тэтгэврийн даатгал	-	10,585,406.09
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,245,341.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,218,576.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	242,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,929,419.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	19,246,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	7,646,400.00
210302	Түлш, халаалт	-	9,943,900.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,655,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	16,226,764.57
210401	Бичиг хэрэг	-	4,428,309.00
210402	Тээвэр, шатахуун	-	8,132,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,152,900.01
210404	Ном, хэвлэл	-	27,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	5,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,480,705.56
2105	Нормативт зардал	-	179,806,579.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	179,806,579.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	221,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	68,000.00
210604	Урсгал засвар	-	153,000.00



2107	Томилолт, зочны зардал	-	11,919,448.00
210701	Гадаад албан томилолт	-	9,559,248.00
210702	Дотоод албан томилолт	-	1,931,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	428,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,517,329.60	340,015,137.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,517,329.60	337,375,747.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,046,310.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	71,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	487,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	34,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,876,180.64	171,914,429.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,876,180.64	68,616,127.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,710,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	99,588,302.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	85,630,960.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,519,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,793,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,726,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	77,111,960.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	77,111,960.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	282,466,778.44	156,693,185.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	282,466,778.44	156,693,185.69

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	94,421,646.39	1,111,124,751.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,421,646.39	109,609,021.99
120	Нийтлэг татварын бус орлого	94,421,646.39	109,609,021.99
120002	Хүүгийн орлого	-	192,509.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,421,646.39	109,416,512.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,421,646.39	109,416,512.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,001,515,730.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	714,962,050.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	714,962,050.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	286,553,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	189,823,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	96,730,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	104,072,691.88	1,112,249,999.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,072,691.88	1,112,249,999.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,072,691.88	944,699,271.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,286,616.00	125,237,573.13
210101	Үндсэн цалин	69,286,616.00	125,237,573.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,353,514.60	18,220,975.67
210201	Тэтгэврийн даатгал	16,353,514.60	16,713,874.33
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,507,101.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	413,930.00	19,246,197.47
210301	Гэрэл, цахилгаан	-	8,750,100.00
210302	Түлш, халаалт	-	9,944,097.47
210303	Цэвэр, бохир ус	413,930.00	552,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,420,000.00	17,528,700.01
210401	Бичиг хэрэг	-	6,061,850.00
210402	Тээвэр, шатахуун	1,420,000.00	8,870,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,301,400.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	5,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	700,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	589,600.00
2105	Нормативт зардал	-	44,469,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	44,469,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	14,041,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,881,600.00
210602	Тавилга	-	4,184,000.00
210604	Урсгал засвар	-	975,780.00

2107	Томилолт, зочны зардал	-	11,619,448.00
210701	Гадаад албан томилолт	-	9,559,248.00
210702	Дотоод албан томилолт	-	1,931,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	128,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,374,618.00	625,710,589.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	620,938,479.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,046,310.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,691,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	34,300.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	5,374,618.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,224,013.28	68,624,557.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,224,013.28	64,214,557.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,410,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	167,550,728.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,438,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,093,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	345,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	161,112,728.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	161,112,728.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(9,651,045.49)	(1,125,247.39)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(9,651,045.49)	(1,125,247.39)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,776,292.88	1,125,247.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,125,247.39	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,233,840,996.88	451,141,816.06	(663,908,166.84)	1,021,074,646.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,233,840,996.88	451,141,816.06	(663,908,166.84)	1,021,074,646.10
Тайлант үеийн үр дүн	-	-	156,693,185.69	156,693,185.69
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,233,840,996.88	451,141,816.06	(507,214,981.15)	1,177,767,831.79

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/төгрөг/ Хувь
Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	1,125,247.39	(1,125,247.39)	
<b>1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ДҮН</b>	<b>714,962,050.00</b>	<b>684,283,149.66</b>	<b>30,678,900.34</b>	<b>95.7</b>
<b>А. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	
1.3. Бараа үйлчилгээний бусад зардал	714,962,050.00	684,283,149.66	30,678,900.34	95.7
Цалин хөлс болон нэмэгдэл	-	-	-	-
Үндсэн цалин	-	-	-	-
Нэмэгдэл	-	-	-	-
Унаа хоол	-	-	-	-
.Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-	-	-
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	-	-	-
Тэтгэврийн даатгал	-	-	-	-
Тэтгэмжийн даатгал	-	-	-	-
ҮОМШ өвчний даатгал	-	-	-	-
Ажилгүйдлийн даатгал	-	-	-	-
ЭМД-лын хураамж	-	-	-	-
1.3. Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
Байр ашиглалтын зардал	13,871,800.00	13,871,800.00	-	100.0
Гэрэл цахилгаан	7,646,400.00	8,750,100.00	(1,103,700.00)	114.4
Түлш халаалт	4,569,700.00	4,569,700.00	-	100.0
Цэвэр, бохир ус	1,655,700.00	552,000.00	1,103,700.00	33.3
Хангамж бараа материалын зардал	11,396,800.00	11,396,000.00	800.00	100.0
Бичиг хэрэг	4,761,200.00	4,761,200.00	-	100.0
Тээвэр, шатахуун	5,068,800.00	5,068,000.00	800.00	100.0
Шуудан, холбоо, интернэт	866,800.00	866,800.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх	700,000.00	700,000.00	-	100.0
Норматив зардал	42,267,200.00	42,267,200.00	-	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,267,200.00	42,267,200.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	644,826,250.00	614,148,149.66	30,678,100.34	95.2
Бусад нийтлэг АҮТ хураамж	642,626,250.00	612,201,649.66	30,424,600.34	95.3
Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,200,000.00	1,946,500.00	253,500.00	88.5
Бараа ажил үйлчилгээний бусад зардал	2,600,000.00	2,600,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,600,000.00	2,600,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>714,962,050.00</b>	<b>684,283,149.66</b>	<b>30,678,900.34</b>	<b>95.7</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>714,962,050.00</b>	<b>684,283,149.66</b>	<b>30,678,900.34</b>	<b>95.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	714,962,050.00	684,283,149.66	30,678,900.34	95.7
Тохируулсан орлого зардал		(1,125,247.39)		

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	-	
Урсгал шилжүүлэг			-	
Нэг удаагийн буцалтгүй тусламж			-	
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж			-	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАД БҮГД	32	32	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	23	23	-	100.0
Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөг/
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,729,231.47
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	12,729,231.47
Бараа, үйлчилгээний зардал	-	12,729,231.47
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	11,222,130.13
Үндсэн цалин	-	11,222,130.13
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,507,101.34
Эрүүл мэндийн даатгал	-	1,507,101.34
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	12,729,231.47
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,729,231.47
Төсвийн байгуулагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,729,231.47



## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/13/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРАТОРИ УТҮГ</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд худалдан авалт хийхдээ харилцагч байгууллагын зарлагын баримттай боловч төлбөрийн баримт /и баримт/-ыг хавсаргаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Байгалмаа
2	ХХОАТ-ын хөнгөлөлт буруу тооцож олгосон.	291.9	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Байгалмаа
3	Шилэн дансанд 9 удаагийн мэдээг хугацаа хоцорч , цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн гүйлгээг мэдээлээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Байгалмаа

